

ЗАХИАЛАГЧ:
ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
Л.МЭНДБАЯР

НИЙЛҮҮЛЭГЧ:
“ТЭГШ-АНАР” ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ДОЛГОЖАВ

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ-2024

“Хэнтий аймгийн сумдын эрүүл мэндийн төвүүд, УАУЭмнэлэгт хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах” ХЭАЭМГ/20240102001

- БАГЦ №3 Бүх төрлийн антибиотикууд болон халдварын, нянгийн эсрэг бэлдмэлүүд
- БАГЦ №5 Даавар, дотоод шүүрэл, элэг цөс, ходоод гэдэс, нойр булчирхай болон умайн булчинд нөлөөлөх эмүүд
- БАГЦ №7 Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх, нүдний өвчний ба харшлын эсрэг эмүүд
- БАГЦ №11 Нэг удаагийн зүү, тариур

2024 оны 03 сарын 11

Чингис хот

Нэг. Гэрээний зорилго

Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Хоёр. Гэрээний ерөнхий нөхцөл

Нэг талаас **Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **“Тэгш-Анар” ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож **2024 оны 03 сарын 11-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ** (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
Захиалагч нь **№3 багцад 23,624,650 төгрөгийн, №5 багцад 42,253,700 төгрөгийн, №7 багц 9,711,360 төгрөгийн дүнтэй, №11 багцад 10,062,600 төгрөгийн дүнтэй** төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
2. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг **85,652,310 төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгавар болгоно.**

3. Нийлүүлэгч багц тус тус эм, эмнэлгийн хэрэгслийг **2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 9 дүгээр сарын 20-ны** өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

- Нийлүүлэгч нь захиалагчийн захиалсан эм, эмнэлгийн хэрэгсэл тус бүрийг тохиролын гэрчилгээний хамт
- Сумдын ЭМТөвүүдийн эм, эмнэлгийн хэрэгслийг улирал улирлаар нийлүүлэх ба өмнөх улирлын сүүлийн сарын 20-ны өдрийн дотор хуваарийн дагуу сум тус бүрт хүлээлгэн өгч, нийлүүлнэ.
- Нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хүчинтэй хугацаа 2 жилээс доошгүй байна.

4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

5. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согот арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
6. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согот арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
7. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Гурав. Захиалагч талын эрх, үүрэг

3.1 Захиалагч нь нийлүүлэгчийн гэрээний дагуу нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслэлийн үнийг хүлээж авсанаас хойш 60 хоногийн дотор төлсөн байна. Эмийн чанарын баталгаажилт ирээгүй болон хуваарийн дагуу эмийг дутуу нийлүүлсэн тохиолдолд төлбөр тооцоог хийхгүй.

3.2 Захиалагч гэрээгээр нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгслэлийн үнэ /тендерийн үнэ/-ийг өсгөхгүйгээр тэдгээрийн тоо ширхэгийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 34.1.4 заалтын дагуу шинээр нэвтэрч буй технологи тухайн жилийн өвчлөлийн ачаалал, давтагдашгүй хүчин зүйл зэргээс шалтгаалан 20 хүртэлх хувиар нэмэгдүүлэх эсвэл бууруулах эрхтэй. Мөн тухайн жилд захиалсан эм барааг тоогоор нь аваагүй ч нийт үнийн дүнгээр гэрээний өртөтг хүрсэн тохиолдолд гэрээг биелүүлсэнд тооцно.

3.3 Нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслэлийн чанар, үнэ, техникийн тодорхойлолтын өгөгдөлд тогтмол хяналт тавьж, шаардлага хангахгүй, дуусах хугацаа нь ойртсон эмийг тухай бүрд нь хариу мэдэгдэж ажиллана.

3.4 Гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэж, гүйцэтгэлийг дараа оны тендерт харгалзан үзнэ.

3.5 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлагыг хүлээж байна.

Дөрөв. Нийлүүлэгч талын хүлээх үүрэг

4.1 Нийлүүлэх эм нь эм, эмнэлгийн хэрэгслэлийн тендерийн бичиг баримтад заасан хугацаа, чанар, савалгаа боодолтой байх ба баглаа боодол савалгааны үнэ эцсийн цэгт хүрэх тээврийн зардлыг нийлүүлэгч байгууллага хариуцна.

4.2 Тээвэрлэлтийн явцад нийлүүлж буй эм, эмнэлгийн хэрэгслэл эвдэрч гэмтсэн тохиолдолд нөхөн төлнө.

4.3 Нийлүүлэгч энэ гэрээний дагуу шалгарсан багц тус бүрээр тусад нь эмийн падааныг бичиж, нийлүүлэлтийн хуваарийг чанд мөрдөн улиралаар эм, эмнэлгийн хэрэгслэлийг нийлүүлнэ.

4.4 Эм тариаг тасалдуулсанаас үйлчлүүлэгчийн эмчилгээ оношлогоонд доголдол, тасалдал гарсан хариуцлагыг нийлүүлэгч байгууллага хүлээх ба хугацаа хожимдсон 7 хоног тутамд 0,5%-ийн алданги тооцно.

4.5 Эмийн төсвийн хүрэлцээгүй байдал хүн амын өвчлөл ихсэх зэрэг шалтгааны улмаас захиалагч гэрээний үнийг хугацаандаа шилжүүлээгүй тохиолдолд нийлүүлэгч эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангаж эмнэлгүүдийн хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлнэ.

4.6 Нийлүүлж буй эм, эмнэлгийн хэрэгслийн дуусах хугацаа болон тээвэрлэлтийг онцгой анхаарч тухайн онд хугацаа дуусах эмийг огт нийлүүлэхгүй байх.

4.7 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөлд нийцүүлэн барааг хугацаанд нь нийлүүлж мөн нийлүүлж байгаа эм барааны чанарыг бүрэн хариуцаж чанарын сертификатыг эм бүрд дагуулна.

4.8 Гэрээний хугацаанд нийлүүлэхээр санал болгосон гарал үүслийн улсын эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх ба хуваарийн дагуу хугацаанд нь авчирч өгөх хариуцлагыг хүлээнэ.

4.9 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

Тав. Гэрээний хүлээх хариуцлага

5.1 Энэхүү гэрээний хэрэгжилтийг бүтэн жилээр дүгнэх ба хоёр тал харилцан баталгаажуулна.

5.2 Гэрээ цуцлах

5.2.1 Нийлүүлэгч тал эм, эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлэх хугацаанд нь /хуваарийн/ нийлүүлээгүйгээс эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн нь захиалагч байгууллагын чанарын алба болон мэргэжлийн байгууллагын хяналт үнэлгээгээр тогтоогдсон бол.

5.2.2 Захиалагчаас эм, эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлэхтэй холбоотойгоор удаа дараагийн албан шаардлага авсан бол

5.2.3 Гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээг цуцалж дараагийн компанитай гэрээг байгуулна.

5.2.4 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан факсаар харилцана.

Захиалагчийг төлөөлж:

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн
газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн
мэргэжилтэн:

..... О.Энх-Уянга

Захиалагчийн хаяг:

Хэнтий аймаг, Хэрлэн сум 4-р баг,
Эрүүл мэндийн газрын байр
Утас: 88032849

Нийлүүлэгчийг төлөөлж:

“Тэгш-Анар” ХХК-ийн Тендер
хариуцсан эмч:

..... Э.Номин-Эрдэнэ

Нийлүүлэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
3-р хороо, Капитал Центр 1303 тоот
Утас: 8667-3535

Харилцах данс: 5227068909 /ХААН/

РД: 5602297